



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 4/266

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.18, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.2.11, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох байгууллагын нэрийг нэгдүгээр, эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын чиглэл, байршил, хаягийг өөрчлөн гэрчилгээг шинээр олгохыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс (Л.Лхамсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийг сунгасан, олгосон байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Д.БАТСАЙХАН

Zahiramj 2020

... 811200777

Аймгийн Засаг даргын 2020 оны 06 сарын 29  
өдрийн 06...р захирамжийн нэгдүгээр хавсралт




Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгосон байгууллага

д/д	Байгууллагын нэр	Олгосон он сар, өдөр	Хугацаа
1	Сонгино –Чандмана ХХК-ны эмийн сан	2020.05.22	3 жил

.....О.....

Аймгийн Засаг даргын 2020 оны 06 сарын 29 өдрийн захирамжийн хоёрдугаар хавсралт



Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж байгаа байршил хаягийг өөрчлөн зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгох байгууллагууд

д/д	Одоо үйл ажиллагаа эрхлэж буй байршил, хаяг	Үйл ажиллагааны чиглэл	Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх байршил хаягийн өөрчлөлт	Үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт
1	“Одчим наран” хувийн эмнэлэг Улиастай сум, Жинст баг	Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа	“Одчим наран” хувийн эмнэлэг Алдархаан сумын “Лааны булан”-нд	Мэдрэлийн эмгэг эмчлэх, эрүүл мэндийн болон лабораторийн үйл ажиллагаа эрхлэх
2	Хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

.....О.....